



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/897

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын дунд, ахлах ангийн ширээ сандал шинэчлэх ажлын гүйцэтгэгч "Улаанбүрд" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:


Д.Нямдорж – Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн

Д.Дөмөгтүшиг – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Даваасамбуу – Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ж.Батбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Жаргалант сумын дунд, ахлах ангийн ширээ сандал шинэчлэх ажлын гүйцэтгэгч "Улаанбүрд" ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганболд/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02-04287

D/Zax-A/897-Da